



ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амьрсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005404, 70005405
Факс: +976-70005403
Э.Шуудан: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

"АРД ДААТГАЛ" ХХК -ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санал дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Ард Даатгал" ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "Ард Даатгал" ХХК -ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан даатгалын багц дүрмийн дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудитын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.



ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2018 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 16-НЫ ӨДӨР

Аудитлагдсан тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (сая төгрөг)	2017	2016
ХӨРӨНГӨ		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	793.30	405.15
Хөрөнгө оруулалт	5,783.70	4,395.17
Авлага	1,990.82	1,943.80
Бусад санхүүгийн бус хөрөнгө	171.59	80.88
Даатгалын хөрөнгө	954.71	542.91
Үндсэн хөрөнгө - цэвэр	2,032.56	2,173.23

НИЙТ ХӨРӨНГӨ 11,726.64 9,541.14

ӨР ТӨЛБӨР		
Өр төлбөр	929.91	943.45
Орлогод тооцоггүй хураамжийн нөөц	3,894.94	3,012.00
Нөхөн төлбөрийн нөөц сан:		
Учирсан боловч мэдэгдээгүй ХНС	531.50	395.64
Мэдсэн боловч төлөөгүй ХНС	29.83	8.02
Учирч болзошгүй ХНС	462.07	298.28
Тусгай нөөц сан	641.25	641.25
Нийт нөхөн төлбөрийн нөөц сан	1,664.65	1,343.18
Нийт өр төлбөр	6,489.50	5,298.64

Өөрийн хөрөнгө		
Энгийн хувьцаа	3,500.00	3,500.00
Хуримтлагдсан ашиг	1,737.14	742.51
Нийт өөрийн хөрөнгө	5,237.14	4,242.51

НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН 11,726.64 9,541.14

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН (сая төгрөг)

Даатгалын үйл ажиллагаа	2017	2016
Даатгалын хураамжийн орлого	10,355.13	7,172.29
Даатгалын хураамжийн буцаалт	-141.38	-131.93
Давхар даатгалын хураамжийн зардал	-3,301.85	-1,346.38
Даатгалын хураамжийн цэвэр орлого	6,911.89	5,693.98

Орлогод тооцсон хураамж 6,028.95 5,842.94

Нөхөн төлбөрийн зардал		
Давхар даатгагчийн төлсөн нөхөн төлбөр	-4,063.12	-2,595.76
Буруутай этгээд хариуцсан нөхөн төлбөр	1,529.57	
	22.68	32.48
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	-2,510.87	-2,563.28

Даатгалын гэрээний зардал		
Давхар даатгалын шимтгэлийн орлого	-916.66	-994.55
Хөрөнгө оруулалтын олз, гарз	128.25	45.64
	1,400.03	801.37
Даатгалын үйл ажиллагааны ашиг/(алдагдал)	3,828.99	3,159.59

Ажиллагсадтай холбоотой зардал		
Үйл ажиллагааны бусад зардал	-1,423.68	-1,483.73
Үйл ажиллагааны бусад орлого	-1,199.78	-1,109.80
Үйл ажиллагааны бусад орлого	318.36	21.35
Үйл ажиллагааны бус орлого	97.84	
Үйл ажиллагааны бус зардал	-251.92	-235.03
Санхүүгийн орлого/(зардал)	-109.77	137.24
Бусад ашиг/(алдагдал)	-2,568.96	-2,669.97

Татвар төлөхийн өмнөх ашиг/(алдагдал)	1,260.03	489.62
Орлогын албан татварын зардал	-136.06	-58.48
Татварын дараах ашиг/(алдагдал)	1,123.98	431.13